




# МОНГОЛБАНК

## ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ, САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ



# 2017

# ТҮҮВЭР СУДАЛГАА


### Судалгаа, Статистикийн газар

*Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдлын талаарх түүвэр судалгааны үр дүнг нэгтгэн тайлагнасан тул Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.*



2017 оны 8 сар

# АГУУЛГА



- 4 **ОРШИЛ**
- 5 **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ, ТҮҮВЭРЛЭЛТ**

## **БҮЛЭГ 1**

- 7 Ерөнхий мэдээлэл

## **БҮЛЭГ 2**

- 10 Дэмжлэг
- 12 Санхүүжилтийн байдал

## **БҮЛЭГ 3**

- 21 Бизнесийн орчин

## **БҮЛЭГ 4**

- 29 Дотоод үйл ажиллагаа
- 30 Борлуулалтын орлого
- 32 Зардлын байдал
- 34 **ДҮГНЭЛТ**



## ЗУРАГ, ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 1: Бизнесийн тоо .....	7
Зураг 1. 2: Аж ахуй нэгжийн хэлбэр.....	7
Зураг 1. 3: Аж ахуй нэгжийн өмчийн хэлбэр.....	7
Зураг 1. 4: ААН-ийн үйл ажиллагааны төрөл.....	7
Зураг 1. 5: Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа.....	7
Зураг 1. 6: Аж ахуй нэгжийн ажиллагсдын тоо .....	7
Зураг 1. 7: ААН-ын үйл ажиллагааны лиценз.....	8
Зураг 1. 8: Бизнесийн анхны эх сурвалж.....	8
Зураг 1. 9: ААН-ын санхүүгийн тайлан .....	8
Зураг 2. 1: ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд.....	10
Зураг 2. 2: ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд, салбараар.....	10
Зураг 2. 3: ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд.....	11
Зураг 2. 4: Цаашид авах арга хэмжээ.....	11
Зураг 2. 5: ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт авсан байдал.....	12
Зураг 2. 6: Санхүүжилтийн эх сурвалж.....	12
Зураг 2. 7 Санхүүжилтийн зарцуулалт.....	12
Зураг 2. 8: Санхүүжилт аваагүй шалтгаан.....	13
Зураг 2. 9: Зээлийн нөхцөл хатуу байсан шалтгаан.....	13
Зураг 2. 10: Зээл авах нөхцөлөө хангаагүй шалтгаан.....	13
Зураг 2. 11: Ажилчдын тоо өссөн эсэх.....	14
Зураг 2. 12: Санхүүжилт авах хэрэгцээ.....	15
Зураг 2. 13: Санхүүжилтийн эх сурвалж.....	15
Зураг 2. 14: Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ.....	15
Зураг 2. 15: Санхүүжилтийн зарцуулалт .....	16
Зураг 2. 16: Шаардлагатай санхүүжилтийн хугацаа.....	16
Зураг 2. 17: Үйл ажиллагааны төлөв.....	16
Зураг 2. 18: Зээлээ хугацаанаас хэтрүүлсэн эсэх.....	16
Зураг 2. 19: Санхүүжилт авсан эсэх, салбараар.....	17
Зураг 2. 20: Санхүүжилтийн эх сурвалж, салбараар.....	17
Зураг 2. 21: Санхүүжилт аваагүй шалтгаан, салбараар.....	17
Зураг 2. 22: Санхүүжилтээ хаанаас авах вэ?.....	18
Зураг 2. 23: Санхүүжилтийн хэмжээ.....	18
Зураг 2. 24: Санхүүгийн зарцуулалт.....	18
Зураг 2. 25: Санхүүжилтийн хугацаа, салбараар.....	19
Зураг 3. 1: ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин.....	21
Зураг 3. 2: ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин /үзүүлэлтээр/.....	21
Зураг 3. 3: Макро эдийн засгийн нөлөө .....	22
Зураг 3. 4: Макро эдийн засгийн нөлөө /үзүүлэлтээр/.....	22
Зураг 3. 5: Макро эдийн засгийн нөлөө /аймгуудаар/.....	22
Зураг 3. 6: Нийгмийн орчин .....	23
Зураг 3. 7: Нийгмийн орчин /үзүүлэлтээр/.....	23
Зураг 3. 8: Нийгмийн орчин /аймгуудаар/.....	23
Зураг 3. 9: Хууль эрх зүйн орчин.....	24



Зураг 3. 10: Хууль эрх зүйн орчин, үзүүлэлтээр.....	24
Зураг 3. 11: Хууль эрх зүйн орчин, аймгуудаар .....	24
Зураг 3. 12: Зах зээлийн орчин .....	25
Зураг 3. 13: Зах зээлийн орчин, үзүүлэлтээр .....	25
Зураг 3. 14: Зах зээлийн орчин, аймгуудаар.....	25
Зураг 3. 15: Санхүүжилтийн орчин.....	26
Зураг 3. 16: Санхүүжилтийн орчин, үзүүлэлтээр .....	26
Зураг 3. 17: Санхүүжилтийн орчин, аймгуудаар.....	26
Зураг 3. 18: Дэд бүтцийн орчин .....	27
Зураг 3. 19: Дэд бүтцийн орчин, үзүүлэлтээр .....	27
Зураг 3. 20: Дэд бүтцийн орчин, аймгуудаар.....	27
Зураг 4. 1: Дотоод орчин, үзүүлэлтээр .....	29
Зураг 4. 2: Дотоод орчин, аймгуудаар.....	29
Зураг 4. 3: Жилийн борлуулалтын орлого .....	30
Зураг 4. 4: Борлуулалтын орлогын өсөлт .....	31
Зураг 4. 5: Өнгөрсөн хугацаанд борлуулалтын орлогын өөрчлөлт .....	31
Зураг 4. 6: Ашигтай ажилласан эсэх .....	31
Зураг 4. 7: Жилийн борлуулалтын орлого, аймгуудаар .....	32
Зураг 4. 8: Зардлын байдал.....	32
Зураг 4. 9: Зардлын байдал, үзүүлэлтээр .....	32
Зураг 4. 10: Зардлын хуваарилалт.....	33
Зураг 4. 11: Зардлын байдал, аймгуудаар.....	33
Хүснэгт 4. 1: Дотоод орчин, үзүүлэлтээр.....	30

## ОРШИЛ

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг эрчимтэй дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн нэн тэргүүний зорилго хэвээр байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлт хүртээмжтэй байхад чухал үүргийг гүйцэтгэдэг. Түүнчлэн ЖДҮ-ийг хөгжүүлснээр орлогын тэгш бус байдлыг бууруулах, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх, хувийн секторын хөгжлийг хангахад онцгой хувь нэмэр үзүүлдэг.

Монгол улсын Засгийн газраас ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож 2007 онд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг батлан гаргаж, 2008 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Жижиг, дунд үйлдвэрийн газар, 2009 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг байгуулсан. Төрөөс ЖДҮ-ийг хөгжүүлэх, бизнесийн орчинг сайжруулахад анхаарч 2009 оныг “Үйлдвэрлэлийг дэмжих жил”, 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”, 2011 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”, 2012 оныг “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ээр тус тус зарласан бөгөөд 2014 онд Засгийн газраас “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр (2014-2016)”-ийг баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2016 оныг “Дотоодын үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих жил”-ээр зарлан жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж иржээ.

Монголбанкнаас Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ-ийн өнөөгийн хөгжил, тулгарч буй саад бэрхшээл болон санхүүжилтийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор түүвэр судалгааг жил бүр, Улаанбаатар хот болон 21 аймаг дахь бизнес эрхлэгч нарын дунд явуулдаг.

Энэхүү түүвэр судалгааг Монголбанкнаас 6 дахь жилдээ явуулж байгаа бөгөөд Монгол улсад идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй нийт 1970 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгч нарыг хамрууллаа. Судалгааг явуулахдаа “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу ЖДҮ эрхлэгчдийг ангилж, түүвэрлэн хамруулсан бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа эдийн засгийн салбар, газар зүйн байршил, ажилчдын тоо зэргийг харгалзан үзэж сан амсаргүй түүврийн аргаар судалгааны нэгжийг сонгон авсан болно.

Энэ удаагийн судалгаагаар Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчдийн өнөөгийн байдал, хөгжил, дэмжлэг, үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлс, санхүүжилт болон зардлын байдлыг тодорхойлохыг зорилоо.

Судалгааны ажил нь үндсэн 4 бүлгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны төрөл, үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа, ажиллагсдын тоо, хөрөнгө оруулалтын хэлбэр зэргийг дэлгэрэнгүй авч үзлээ. Хоёрдугаар бүлэгт ЖДҮ эрхлэгчдэд ямар төрлийн байгууллагууд хэрхэн дэмжлэг үзүүлж байгааг тогтоохын зэрэгцээ бизнес эрхлэгчдийг дэмжихэд цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг нэгтгэн авч үзэв. Мөн энэ бүлэгт ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт авахтай холбоотой үүсч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж цаашид санхүүжилт авах хэрэгцээ, хүсч буй зээлийн үндсэн нөхцөлийн талаар судаллаа. Гуравдугаар бүлэгт ЖДҮ-ийн бизнесийн орчныг макро эдийн засгийн орчин, нийгэм улс төрийн орчин, санхүүжилтийн орчин, зах зээлийн орчин болон дэд бүтцийн орчин гэсэн үндсэн 6 хэсэгт хуваан судлав. Дөрөвдүгээр бүлэгт ЖДҮ эрхлэгчдийн дотоод үйл ажиллагаа болон орлого, зарлагын талаар авч үзлээ.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГАЧЛАЛ, ТҮҮВЭРЛЭЛТ

### Зорилго

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн хөгжил, үйл ажиллагааны өнөөгийн байдал, санхүүжилт, тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах, үнэн зөв мэдээллийг гаргахад оршино.

Санал асуулга авах зорилгот бүлэг нь ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгжийн эзэн/гүйцэтгэх удирдлага (захирал, гүйцэтгэх, ерөнхий менежер, нягтлан гэх мэт) ба хувиараа хөдөлмөр эрхлэгч нар байв.

### Аргачлал

Судалгааны мэдээллийн санг **Дэлхийн банкны “САРИ”** системд суурилан санал асуулга явуулах замаар цуглуулсан бөгөөд судалгаанд хамрагдсан ЖДҮ-ийн удирдлага, холбогдох албан тушаалтнаас<sup>1</sup> ярилцлагын аргаар мэдээлэл авсан болно.

Судалгааны санал асуулгыг бусад орнуудын хийсэн ижил төстэй судалгааны санал асуулгууд дээр үндэслэн боловсруулав.

### Түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийн нэгжийг сонгохдоо ААН-үүдийн байршил, ажиллагсдын тоо болон үйл ажиллагааны чиглэлийг харгалзан үзэж, эх олонлогийг төлөөлөхүйц түүврийг санамсаргүй түүврийн аргаар сонголоо. Оновчтой түүврийн хэмжээг тодорхойлохдоо түүврийн харьцаа болон дунжийн хувьд 95%-ийн итгэх интервалд (хамгийн багадаа 5%-ийн ач холбогдлын түвшинд) статистикийн хувьд найдвартай байх, хамгийн бага хангалттай хэмжээний түүврийг үүсгэхээр сонголоо<sup>2</sup>.

Түүврийн эх олонлогт 2017 оны эцсийн байдлаар Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны Бизнес регистрийн санд<sup>3</sup> бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 75,796 аж ахуйн нэгжүүдийг хамрууллаа. Статистик тооцооллоос оновчтой түүврийн хэмжээг Улаанбаатар хотоос 1000, аймгуудаас 30-50 буюу нийт 1850 байхаар төлөвлөв. Санал асуулгын хариултын чанараас хамааран зарим газраас илүү эсвэл дутуу тооны санал

асуулга авах магадлалтай байсан бөгөөд нийт дүнгээр төлөвлөсөн хэмжээнээс 5%-иар илүү буюу 1,950 түүвэр сонгов. Санал асуулгад оролцогчдыг аймаг, нийслэлээр авч үзвэл нийт оролцогчдын 57%-ийг Улаанбаатар хотын, 43%-ийг орон нутгийн ЖДҮ эрхлэгчид эзэлж байгаа бөгөөд хувийн жинг харвал ихэнх аймгуудад 2-3 хувийн хооронд жигд тархалттайгаар хамрагдав.

### Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид

	Үйл ажиллагаа явуулж буй ААН		Судалгаанд хамрагдсан ААН		
	Тоо	Хувийн жин	Авсан	Хувийн жин	Нийт ААН-д эзлэх хувь
Архангай	1054	1,4%	35	1,8%	3,3%
Баян-Өлгий	1489	2,0%	44	2,3%	3,0%
Баянхонгор	1025	1,4%	33	1,7%	3,2%
Булган	1132	1,5%	33	1,7%	2,9%
Говь-Алтай	811	1,1%	25	1,3%	3,1%
Говьсүмбэр	318	0,4%	22	1,1%	6,9%
Дархан	2062	2,7%	71	3,6%	3,4%
Дорноговь	1050	1,4%	42	2,2%	4,0%
Дорнод	1416	1,9%	51	2,6%	3,6%
Дундговь	622	0,8%	31	1,6%	5,0%
Завхан	1259	1,7%	37	1,9%	2,9%
Орхон	2226	2,9%	60	3,1%	2,7%
Өвөрхангай	1283	1,7%	46	2,4%	3,6%
Өмнөговь	1385	1,8%	3	0,2%	0,2%
Сүхбаатар	762	1,0%	24	1,2%	3,1%
Сэлэнгэ	2143	2,8%	62	3,2%	2,9%
Төв	1254	1,7%	51	2,6%	4,1%
Увс	1481	2,0%	8	0,4%	0,5%
Улаанбаатар	48519	64,0%	1116	57,2%	2,3%
Ховд	1854	2,4%	65	3,3%	3,5%
Хөвсгөл	1621	2,1%	55	2,8%	3,4%
Хэнтий	1030	1,4%	36	1,8%	3,5%
<b>Нийт</b>	<b>75796</b>	<b>100,0%</b>	<b>1950</b>	<b>100,0%</b>	<b>2,6%</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ЖДҮ-ийн түүвэр судалгаа

<sup>1</sup> ААН-ийн үйл ажиллагаа, санхүүжилтийн талаар мэдээлэл өгөх бүрэн боломжтой удирдах албан тушаалтнууд.

<sup>2</sup>  $n = \frac{z^2 s^2 N}{\Delta^2 N + z^2 s^2}$ ; n-хамгийн бага түүврийн хэмжээ, z- итгэх интервалд харгалзах критик утга (95%-ийн итгэх түвшинд 1.96-тай тэнцүү байна), s- стандарт хазайлт, N- эх олонлогийн хэмжээ

Δ- үнэлгээний нарийвчлал.

<sup>3</sup> ҮСХ, Статистикийн мэдээ, 2014 он 12 сар.




# БҮЛЭГ 1




## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Аж ахуй нэгжийн өмчийн хэлбэр




Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа



ААН-ийн үйл ажиллагааны төрөл



Аж ахуй нэгжийн ажиллагсдын тоо



**Аж ахуйн нэгжийн өмчлөлийн хэлбэр, үйл ажиллагааны төрөл:** Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх хувийг дотоодын хөрөнгө оруулалттай, худалдаа болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ХХК-иуд эзэлж байна.

**Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа, ажиллагсдын тоо:** Судалгаанд оролцогчдын тал нь 1-5 жил, үлдсэн тал хувь нь 5-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж байна. Дийлэнх нь 1-9 хүртэлх тооны ажиллагсадтай бичил бизнес эрхлэгчид хамрагдлаа.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү бүлэгт санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн талаарх ерөнхий мэдээллийг танилцуулна.

### Бизнесийн тоо

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн 79% нь зөвхөн нэг чиглэлээр бизнес эрхэлдэг бол үлдсэн хувь нь олон төрлийн салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулдаг байна.

### Аж ахуй нэгжийн хэлбэр

Судалгаанд оролцсон ААН-үүдийн 54% нь хувиараа эрхлэх аж ахуй, 38% нь ХХК, 3% нь нөхөрлөл, 2% нь хоршоо, 1% нь ХК хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

### Аж ахуй нэгжийн өмчлөлийн хэлбэр

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийг өмчлөлийн хэлбэрээр нь авч үзвэл дийлэнх хэсэг буюу 97% нь дотоодын хөрөнгө оруулалттай ААН-үүд эзэлж байна. Харин гадаадын хөрөнгө оруулалттай 1%, холимог өмчлөлтэй ЖДҮ эрхлэгчид 2%-ийг эзэлж байна.

Судалгаанд оролцсон ААН-үүдээс дотоодын хөрөнгө оруулалттай ЖДҮ эрхлэгч нар түлхүү оролцсон. Сүүлийн жилүүдэд ГШХО эрс буурч, зогсонги байдалд орсноор гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн тоо буурч байна.

### ААН-ийн үйл ажиллагааны төрөл

Санал асуулгад оролцогчдын ихэнх нь буюу 74% нь худалдаа болон үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна. Харин үйлдвэрлэлийн салбарт 13%, ХАА-н салбарт 5%, барилгын салбарт 4% нь үйл ажиллагаа явуулж байна.

### Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа


ЖДҮ эрхлэгчдийг үйл ажиллагаа явуулж буй хугацаагаар авч үзвэл 14% нь 1 жил хүртэлх, 19% нь 1-3 жил, 19% нь 3-5 жил, 23% нь 5-10 жил, 25% нь 10 дээш жил үйл ажиллагаа эрхэлж байна.

### Ажиллагсдын тоо

Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчдийн дийлэнх буюу 84% нь 1-9 хүртэлх тооны ажиллагсадтай гэж хариулт өгчээ. Харин 13% нь 10-49 хүртэлх тооны ажиллагсадтай бол 50-аас дээш тооны ажиллагсадтай ЖДҮ эрхлэгчид нийт оролцогчдын 4%-ийг эзэлж байна.


**Зураг 1.1: Бизнесийн тоо**

Хариултын хувиар



**Зураг 1.2: Аж ахуй нэгжийн хэлбэр**

Хариултын хувиар




**Зураг 1.3: Аж ахуй нэгжийн өмчийн хэлбэр**

Хариултын хувиар




**Зураг 1.4: ААН-ийн үйл ажиллагааны төрөл**

Хариултын хувиар




**Зураг 1.5: Үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа**

Хариултын хувиар



**Зураг 1.6: Аж ахуй нэгжийн ажиллагсдын тоо**

Хариултын хувиар



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)



### ААН-ын үйл ажиллагааны лиценз

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 60% нь үйл ажиллагаа явуулах лицензтэй байгаа бол 36% нь лиценз байхгүй, 4% нь бизнес эрхлэх лиценз авахаар ажиллаж байна.

### Бизнесийн анхны эх сурвалж


Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 57% нь өөрийн хөрөнгөөр анх бизнесээ эхлүүлж байжээ. Харин 18% нь банкны зээлээр, 16% нь гэр бүлийн хамтын хөрөнгөөр анх бизнесээ санхүүжүүлжээ.

### ААН-ийн санхүүгийн тайлан

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн 63% нь санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг бол 32% нь гаргах шаардлагагүй гэж үзжээ. Харин 5% санхүүгийн тайлан баланс гаргахад бэрхшээлтэй байдаг гэж хариулжээ.

Зураг 1.7: ААН-ын үйл ажиллагааны лиценз

Хариултын хувиар



Зураг 1.8: Бизнесийн анхны эх сурвалж

Хариултын хувиар



Зураг 1.9: ААН-ын санхүүгийн тайлан

Хариултын хувиар



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

# БҮЛЭГ 2




## ДЭМЖЛЭГ, САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛ

ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд



ЖДҮ эрхлэгчдийн Санхүүжилтийн эх сурвалж



Зээл авах нөхцөлөө хангаагүй шалтгаан



## ДЭМЖЛЭГҮҮД

### ЖДҮ-ийг хамгийн ихээр дэмждэг байгууллагууд

Санал асуулгын дүнгээр ЖДҮ эрхлэгчдийг арилжааны банкууд хамгийн ихээр дэмждэг гэсэн үр дүн гарав. Өмнөх жилүүдийн судалгаануудад мөн дээрх үр дүн гарсан. Түүний дараагаар бусад санхүүгийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, засгийн газар, үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо зэрэг бусад байгууллагууд оров. Харин зөвлөгөө өгөх байгууллага, төвүүд болон олон улсын байгууллагуудын ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг хамгийн муу гэсэн үр дүнтэй гарлаа /Зураг 2.1/.

Засгийн газраас ЖДҮ-ийг хөгжүүлэх талаар мянганы хөгжлийн зорилт, тогтвортой хөгжлийн хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги зэрэг бодлогын олон гол баримт бичгүүдэд тусган арга, хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Судалгаанд оролцогчдоос давхардсан тоогоор 10 гаруй хувь нь засгийн газар болон орон нутгийн захиргаа дэмждэг гэсэн хариуг өгчээ.

ХАА, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ эрхлэгчдийн 53% нь засгийн газар, орон нутгийн засаг захиргаа дэмжлэг үзүүлдэг гэж хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ЖДҮ эрхлэгчдийн 67% нь арилжааны банкуудыг дэмждэг гэж хариулсан байна /Зураг 2.2/.

**Зураг 2.1: ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд**

Давхардсан тоогоор



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Зураг 2.2: ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй байгууллагууд, салбараар**



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

### ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд

Санал асуулгын дүнгээр манай улсад ЖДҮ эрхлэгчид голчлон санхүүжилт олгох, сургалт, зөвлөгөө явуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, ЖДҮ эрхлэгчдийн эрх зүйн орчинг сайжруулах замаар дэмжлэг үзүүлдэг байна. Харин ЖДҮ-ийг дэмжих инкубатор төвүүдийг байгуулах, технологийн ололт, дэвшлийг нэвтрүүлэх, ЖДҮ-үүдийг тоног төхөөрөмжийн НӨАТ-аас чөлөөлөх зэрэг дэмжлэг бага үзүүлж байна гэж судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид үзжээ /Зураг 2.3/.

### ЖДҮ-ийг хөгжүүлэх арга хэмжээ

Судалгааны дүнгээр ЖДҮ эрхлэгчид цаашид нэн тэргүүнд татварын таатай орчинг бүрдүүлэх, хөнгөлөлттэй санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох шаардлагатай гэж хариулсан байна. Харин мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, технологийн төв байгуулах, маркетинг дээр дэмжлэг үзүүлэх, сургалт, зөвлөгөөний цар хүрээг нэмэгдүүлэх, шинэ технологийг санаачлагч ААН-үүдийг дэмжих, дэд бүтцийг сайжруулах, албан зөвшөөрлийн хураамжийг бууруулах зэрэг бусад арга хэмжээнүүдийг цаашид хийх шаардлагатай гэж үзсэн аж ахуй нэгжийн тоо нийт ААН-ийн 10 хүрэхгүй хувь байна /Зураг 2.4/.

**Зураг 2.3: ЖДҮ эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэгүүд**

Давхардсан тоогоор



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Зураг 2.4: Цаашид авах арга хэмжээ**

Давхардсан тоогоор



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

## ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙН САНХҮҮЖИЛТ

### 2.1. ӨНГӨРСӨН ХУГАЦААНД САНХҮҮЖИЛТЭНД ХАМРАГДСАН БАЙДАЛ

Улсын хэмжээнд нийт 1,970 ЖДҮ эрхлэгч судалгаанд хамрагдсанаас уг асуултад 1,909 нь хариулж, 61 нь хариулаагүй байна.

#### Санхүүжилт авсан байдал

Судалгаанд хариулсан нийт 1,909 ЖДҮ эрхлэгчдийн 1063 нь буюу 56% нь тодорхой хэмжээний санхүүжилт авч байсан бөгөөд үлдсэн 44% нь санхүүжилт авч байгаагүй байна. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ эрхлэгчдийн 590 буюу 72% нь урьд өмнө зээл авах болон бусад хэлбэрээр гадаад санхүүжилтэд хамрагдаж байжээ. Харин Улаанбаатар хотын хэмжээнд ЖДҮ-ийн 473 буюу 43% нь зээл болон бусад хэлбэрийн санхүүжилтэд хамрагдаж байсан бол 622 буюу 57% нь санхүүжилт авч байгаагүй гэж хариулжээ /Зураг 2.5/.

Түүвэр судалгааны үр дүнгээс харахад хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ эрхлэгчид Улаанбаатар хотын ЖДҮ эрхлэгчтэй харьцуулахад гадаад санхүүжилтэд харьцангуй өндөр хамрагддаг байна.

#### Санхүүжилтийн эх сурвалж


Түүвэр судалгаанд оролцсон нийт 1,909 ЖДҮ эрхлэгчдийн 1063 буюу 56% нь өнгөрсөн хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэх болон бизнесээ өргөтгөх зорилгоор гадаад санхүүжилтэд хамрагджээ. Тэдгээр ЖДҮ эрхлэгчдийн давхардсан тоогоор ихэнх буюу 81% нь банкны зээл авч санхүүжиж байсан бол 7% нь ББСБ-ын зээл, 6% нь хөнгөлөлттэй зээл, 4% нь хамаатан садан болон найз нөхдөөс зээл авах замаар гадаад санхүүжилт авч байжээ /Зураг 2.6/.

#### Санхүүжилтийн зарцуулалт

Өнгөрсөн хугацаанд гадаад санхүүжилтэд хамрагдсан 1063 ЖДҮ эрхлэгчид гадаад санхүүжилтийн дийлэнх хэсэг болох 64%-ийг эргэлтийн хөрөнгөд, 12%-ийг машин тоног төхөөрөмж худалдан авах, 9%-ийг бизнесийн үйл ажиллагаа өргөжүүлэх, 8%-ийг барилгаа өргөжүүлэх, 4% шинэ барилга худалдан авахад болон үлдсэн 2%-ийг ажилчдаа сургах болон бусад зардалд зарцуулжээ /Зураг 2.7/.

**Зураг 2.5: ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилт авсан байдал**


(ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Зураг 2.6: Санхүүжилтийн эх сурвалж**

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Зураг 2.7: Санхүүжилтийн зарцуулалт**



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

### Санхүүжилт авч чадаагүй шалтгаан

Түүвэр судалгаанд оролцсон нийт 1,909 ЖДҮ эрхлэгчдийн 44% нь өнгөрсөн хугацаанд ямар нэгэн гадаад санхүүжилтэд хамрагдаж байгаагүй. Тэдгээрийн 64% нь өөрийн эх үүсвэрээр санхүүждэг тул өмнө нь санхүүжилтэд хамрагдаагүй бол 28% нь зээлийн нөхцөл хатуу байсан учраас санхүүжилт аваагүй гэж хариулжээ. Үлдсэн 8% нь зээл авах нөхцөлийг хангаагүйн улмаас санхүүжилтэд хамрагдаж чадаагүй байна /Зураг 2.8/.

### Зээл авах нөхцөл чанга байсан шалтгаан

Судалгаанаас харахад өнгөрсөн хугацаанд зээл авах эрмэлзэлтэй байсан хэдий ч зээлийн нөхцөл чанга байснаас зээл авч чадаагүй 471 ЖДҮ эрхлэгчдээс зээлийн ямар нөхцөл чанга байсныг тодруулан асуухад, 55% нь зээлийн хүү өндөр, 13% нь зээлийн хугацаа богино, 18% нь барьцаа хөрөнгийн үнэлгээ бодитой бус, 9% нь зээл олгох үйл ажиллагаа удаан чирэгдэлтэй байсан учраас зээлийн нөхцөлийг чанга гэсэн бол 5% нь бусад шалтгааны улмаас гэж хариулжээ /Зураг 2.9/.


Зээлийн нөхцөл хатуу байгаа хамгийн том шалтгаан нь зээлийн хүү гэж жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид үзэж байна.

### Зээл авах нөхцөлөө хангаагүй шалтгаан

Өнгөрсөн хугацаанд зээл авах хүсэлтээ зээл олгогчдод гаргасан хэдий ч зээлийн шаардлагыг хангаж чадаагүйн улмаас санхүүжилтэд хамрагдаагүй 139 ЖДҮ эрхлэгчид байна. Тэдгээрээс ямар шалтгааны улмаас зээл авч чадаагүйг нь тодруулахад давхардсан тоогоор 38.8% нь барьцаа хөрөнгийн хүрэлцээ муу, 15% нь тогтмол орлогогүй, 7.2% нь тогтмол орлогоо батлах баримтгүй, 10% нь бичиг баримтын зөрчилтэй, 8% нь зээл гаргагчийн баталгаа байхгүй, 5% нь бизнесийн эрсдэл өндөр, 3.6% нь зээлийн мэдээллийн санд сөрөг бүртгэлтэй байгаагийн улмаас зээлийн нөхцөлийг хангаагүй гэж хариулжээ. Харин үлдсэн 11% нь бусад шалтгааны улмаас зээлийн нөхцөлөө хангаагүй гэж хариулсан байна /Зураг 2.10/.


Түүвэр судалгааны үр дүнгээс харахад зээлд хамрагдаж чадахгүй байгаа ЖДҮ эрхлэгчдийн хамгийн том хүндрэл нь барьцаа хөрөнгийн бэрхшээл байна.

Зураг 2.8: Санхүүжилт аваагүй шалтгаан (ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.9: Зээлийн нөхцөл хатуу байсан шалтгаан (ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.10: Зээл авах нөхцөлөө хангаагүй шалтгаан




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)



### Ажилчдын тооны өөрчлөлт

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 12% нь сүүлийн нэг жил нийт ажилчдын тоогоо өсгөсөн байхад 10% нь ажилчдын тоогоо бууруулжээ. Харин дийлэнх хэсэг буюу 76% нь ажилчдын тоогоо өөрчлөөгүй байна /Зураг 2.11/.

Зураг 2.11: Ажилчдын тоо өссөн эсэх



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

## 2.2. САНХҮҮЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### Цаашид санхүүжилт авах хэрэгцээ

Түүвэр судалгаанд хамрагдсан ААН, иргэдийн 65% буюу 1242 ЖДҮ үйл ажиллагаа эрхлэхэд нь цаашид санхүүжилт зайлшгүй хэрэгцээтэй байна гэж үзсэн байхад 27% нь санхүүжилт авах шаардлагагүй гэж үзжээ /Зураг 2.12/.

### Санхүүжилт авах эх сурвалж


Цаашид санхүүжилтийн хэрэгцээ зайлшгүй байгаа гэж үзсэн 1,242 ЖДҮ эрхлэгчдийн 61% нь банкнаас зээл авах замаар санхүүжих хүсэлтэй байгаа бол 30% нь хөнгөлөлттэй зээлд хамрагдах эрмэлзэлтэй байна. Харин борлуулагчаас зээлээр бараа бүтээгдэхүүн авах, гэр бүл найз нөхдөөс зээлэх, зах зээлд хувьцаа гаргах замаар санхүүжих төлөвлөгөөтэй ЖДҮ эрхлэгчид харьцангуй цөөн буюу дунджаар 2% орчим байна /Зураг 2.13/.

Өнгөрсөн хугацаанд ЖДҮ эрхлэгчдийн 81% нь банкнаас зээл авч, 6% нь хөнгөлөлттэй зээлээр санхүүжилтийн эх үүсвэрээ шийдсэнээс харахад ЖДҮ эрхлэгчид банкншийы зээлээс илүү хөнгөлөлттэй зээл авахыг хүсдэг ч хамрагдах боломж хязгаарлагдмал байдаг байна.

### Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ


Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 32.7% нь 10-аас 50 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь шаардлагатай гэж үзсэн бол 28,7% нь 5 сая хүртэлх, 17.4% нь 5-аас 10 хүртэлх, 17.6% нь 50-иас 100 сая хүртэлх, 18.4% нь 100 саяас дээш төгрөгийн санхүүжилт хэрэгцээтэй гэж хариулжээ /Зураг 2.14/.

Зураг 2.12: Санхүүжилт авах хэрэгцээ




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.13: Санхүүжилтийн эх сурвалж



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.14: Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

### Санхүүжилтийн зарцуулалт

ЖДҮ эрхлэгчид хэрэгцээтэй байгаа гэж үзсэн 1,242 ЖДҮ эрхлэгчдийн тэн хагас буюу 51% нь гадаад санхүүжилтээ эргэлтийн хөрөнгөнд, 13% нь машин тоног төхөөрөмж худалдан авахад, 20% нь барилгаа өргөжүүлэх болон шинэ барилга худалдан авахад, 9% нь шинэ ажлын байр бий болгоход, 3% нь өөр бизнес эрхлэхэд зарцуулах төлөвлөгөөтэй байгаа бол үлдсэн 3% нь бусад зүйл зарцуулна гэж хариулжээ /Зураг 2.15/.

Энэхүү зарцуулалтын хувь (Зураг 2.7-д харуулсан) ЖДҮ эрхлэгчдийн өнгөрсөн хугацааны санхүүжилтийн зарцуулалттай төстэй байна. Өөрөөр хэлбэл, ЖДҮ эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахад санхүүгийн эх үүсвэр хамгийн хэрэгцээтэй байна.

### Шаардлагатай санхүүжилтийн хугацаа

Ирээдүйд санхүүжилт шаардлагатай байгаа ЖДҮ эрхлэгчдийн 33.2% нь буюу 410 ЖДҮ эрхлэгчид 5-аас дээш жилийн санхүүжилт шаардлагатай байгаа бол 30.4% нь 3-5 жил, 27.6% нь 1-3 жил, 6.7% нь 1 хүртэл жилийн санхүүгийн эх үүсвэр хэрэгцээтэй байна гэж хариулжээ /Зураг 2.16/.

ЖДҮ эрхлэгчдэд шаардлагатай дундаж санхүүжилтийн хугацаа 3.6 жил байна.

### Үйл ажиллагааны төлөв

Үйл ажиллагаа явуулж байгаа судалгаанд хамрагдсан ЖДҮ-үүдийн 43% нь үйл ажиллагаагаа тогтворжуулахын зэрэгцээ тэлэх боломжийг эрэлхийлж байгаа бол 29% нь үйл ажиллагаагаа тогтворжуулахын тулд үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн 18% нь зах зээлд байр сууриа хэвийн үргэлжлүүлэх (хаалгаа барихгүй)-ийн тулд, 8.3% нь хурдацтай өргөжин тэлэхийн тулд ажиллаж байна хэмээн хариулжээ /Зураг 2.17/.

### Зээлээ хугацаанаас нь хэтрүүлж байсан эсэх


Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 75% нь буюу 1440 ЖДҮ эрхлэгч сүүлийн нэг жилийн хугацаанд зээлээ хугацаанд нь төлж чадаагүй тохиолдол гаргаж байгаагүй бол 20% нь зээлээ хугацаанаас нь хэтрүүлж байжээ /Зураг 2.18/.

Зураг 2.15: Санхүүжилтийн зарцуулалт



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.16: Шаардлагатай санхүүжилтийн хугацаа



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.17: Үйл ажиллагааны төлөв



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.18: Зээлээ хугацаанаас хэтрүүлсэн эсэх



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

## Эдийн засгийн салбарын ангилал

### Санхүүжилт авсан байдал

Салбарын ангиллаар авч үзвэл өнгөрсөн хугацаанд үйлдвэрлэл эрхлэгчдийн ихэнх буюу 70.2% нь, худалдаа эрхлэгчдийн 53.3%, үйлчилгээ эрхлэгчдийн 47.4% нь санхүүжилт авч байсан дүн гарлаа. Эндээс харахад үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд санхүүжилтийн хэрэгцээ бусад салбарын ЖДҮ эрхлэгчтэй харьцуулахад өндөр байдаг байна /Зураг 2.19/.

### Санхүүжилтийн эх сурвалж

Салбаруудын дунд санхүүжилтийн эх үүсвэрийн ялгаа нэг их ажиглагдахгүй байна. Салбараас үл хамааран дийлэнх ЖДҮ эрхлэгчид банкны зээл авч санхүүжсэн байна.


Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа болон бусад салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн банкнаас санхүүжилт авдаг хувь дунджаар 80%-тай байна. Харин үйлдвэрлэл болон ХАА, барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хувь (15%)-ийг худалдаа эрхлэгчидтэй харьцуулахад даруй 13 орчим нэгж хувиар өндөр байна. Түүнчлэн худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн ББСБ-аас зээл авдаг хувь (10%) бусад салбаруудтайгаа харьцуулахад өндөр (6 нэгж хувиар) байна /Зураг 2.20/.

### Санхүүжилт авч чадаагүй шалтгаан

Ямар шалтгааны улмаас санхүүжилтэд хамрагдаагүйг нь тодруулахад үйлчилгээ болон худалдаа эрхлэгчдийн хувьд өөрийн эх үүсвэрээр санхүүждэг гэсэн хариулт 67%-тай байгаа нь үйлдвэрлэл эрхлэгч болон бусад салбарынхантай харьцуулахад 14 нэгж хувиар өндөр байна. Энэ нь худалдаа, үйлчилгээ эрхлэхэд үйлдвэрлэл эрхлэхээс илүү бага хэмжээний санхүүжилт шаардлагатай байдагтай холбоотой байж болно.


Мөн үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд зээлийн үндсэн нөхцөл чанга байгаагаас зээлд хамрагдах боломжгүй гэж хариулсан нь үйлчилгээ болон худалдааны салбарынхантай харьцуулахад 10 орчим нэгж хувиар өндөр байна /Зураг 2.21/.

Зураг 2.19: Санхүүжилт авсан эсэх, салбараар



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.20: Санхүүжилтийн эх сурвалж, салбараар



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.21: Санхүүжилт аваагүй шалтгаан, салбараар



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

### Ирээдүйн санхүүжилтийн эх сурвалж

ЖДҮ эрхлэгчид ихэвчлэн банкнаас санхүүжилт авдаг. Үйлчилгээ болон худалдаа эрхлэгчид бусад салбараас илүүтэйгээр банкны зээл авч санхүүжилтээ шийдэх хүсэлтэй байгаа бол үйлдвэрлэл эрхлэгчид бусад салбарынхантай харьцуулахад илүү (22 нэгж хувь) хөнгөлөлттэй зээл авах замаар ирээдүйн санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэнэ гэж хариулжээ /Зураг 2.22/.

### Хэрэгцээтэй санхүүжилтийн хэмжээ:

Үйлдвэрлэлийн салбарынхан бага хэмжээний санхүүжилт (10 сая хүртэл төгрөг) авах шаардлага бусад салбараас харьцангуй бага байдаг бөгөөд ихэвчлэн 10 сая төгрөгөөс дээш санхүүжилт авах сонирхолтой байна /Зураг 2.23/. Тухайлбал, 10 сая хүртэлх санхүүжилт үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ эрхлэгчдийн 18% нь авах сонирхолтой байгаа нь худалдаа, үйлчилгээний салбарынхантай харьцуулахад дариу 20 нэгж хувиар бага байгаа юм. Харин 100 сая төгрөгөөс дээш хэмжээний санхүүжилт үйлдвэрлэлийн салбарын 29%-д нь хэрэгцээтэй байна.


### Санхүүгийн зарцуулалт

Бүх салбарын ЖДҮ эрхлэгчид эргэлтийн хөрөнгөнд санхүүжилтийн дийлэнхийг зарцуулдаг. Худалдааны салбарт үйл ажиллагаа эрхлэгчид санхүүжилтийн 60%-ийг эргэлтийн хөрөнгөндөө зарцуулдаг нь бусад салбарын үзүүлэлттэй харьцуулахад дунджаар 15 нэгж хувиар өндөр байна.

Худалдааны салбарт эргэлтийн хөрөнгө бусад салбартай харьцуулахад илүү хэрэгтэй байдаг бол үйлдвэрлэлийн салбарт тоног төхөөрөмж бусад салбартай харьцуулахад илүү хэрэгтэй байдаг.


Үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн 18% нь санхүүжилтээ тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулна гэж хариулсан /Зураг 2.24/.

Зураг 2.22: Санхүүжилтээ хаанаас авах вэ?




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.23: Санхүүжилтийн хэмжээ



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 2.24: Санхүүгийн зарцуулалт




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

## Санхүүжилтийн хугацаа

Үйлдвэрлэл эрхлэгчдэд худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэгчидтэй харьцуулахад илүү урт хугацааны санхүүжилт шаардлагатай байдаг байна. Тухайлбал, худалдаа, үйлчилгээний бизнес эрхлэгчдийн 38% нь 3 хүртэлх жилийн хугацаатай санхүүжилт авах сонирхолтой байгаа бол үйлдвэрлэлийн салбарынхны 23% нь 3 хүртэлх жилийн санхүүжилт авах шаардлагатай байна. Энэ нь худалдаа, үйлчилгээ эрхлэгчидтэй харьцуулахад 15 нэгж хувиар бага үзүүлэлт юм. Мөн 5-аас дээш жилийн санхүүжилтийг үйлдвэрлэлийн салбарынхны 45% нь авах сонирхолтой байна /Зураг 2.25/.

Үйлдвэрлэл болон газар тариалан, мал аж ахуй, барилгын салбар эрхлэгчид худалдаа, үйлчилгээ эрхлэгчидтэй харьцуулахад илүү урт хугацааны санхүүжилт авах хүсэлтэй байдаг байна.

Зураг 2.25: Санхүүжилтийн хугацаа, салбараар



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)



# БҮЛЭГ 3



## БИЗНЕСИЙН ОРЧИН

ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин



ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин /үзүүлэлтээр/



**Бизнесийн орчны ерөнхий индекс:** ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн орчны зүгээс нийгэм улс төрийн байдал, макро эдийн засгийн нөлөө, санхүүжилтийн орчин болон хууль, эрх зүйн зохицуулалт гол хүндрэл учруулж байна. Харин зах зээлийн орчин харьцангуй боломжийн буюу бусад орчны индексстэй харьцуулахад бага хүндрэл учруулж байна.

## БИЗНЕСИЙН ОРЧИН

### 3.1. ЕРӨНХИЙ ИНДЕКС

ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг дараах үндсэн 6 бүлэгт (орчин) хуваан авч үзлээ:

- Макро эдийн засгийн нөлөө
- Нийгэм, улс төрийн байдал
- Хууль эрх зүй, төрийн зохицуулалт
- Зах зээлийн орчин
- Дэд бүтцийн хөгжил
- Санхүүжилтийн орчин

Эдгээр 6 бүлэг нь нийт 33 хүчин зүйлс<sup>4</sup>-ээс бүрдэх бөгөөд бүлэг тус бүр нь холбогдох хүчин зүйлсийг агуулсан болно.

Санал асуулгын дүнг нэгтгэж, бизнесийн орчны ерөнхий индексийг тооцоход нийгэм улс төрийн орчин (-0.99), макро эдийн засгийн орчин (-0.80), санхүүжилтийн орчин (-0.64), хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчин (-0.56), зах зээлийн орчин (-0.27), дэд бүтцийн орчин (0.01) гэсэн үнэлгээтэй гарлаа /Зураг 3.1/.


Энэ үнэлгээнээс харахад манай улсын ЖДҮ эрхлэгчдэд бизнесийн орчны зүгээс нийгэм улс төрийн байдал, макро эдийн засгийн нөлөө, санхүүжилтийн орчин болон хууль, эрх зүйн зохицуулалт гол хүндрэл учруулж байна. Харин дэд бүтцийн хөгжил, зах зээлийн орчин харьцангуй боломжийн буюу бусад орчны индекс тэй харьцуулахад бага хүндрэл учруулж байна.

Бизнесийн орчинд нөлөөлөх хүчин зүйлсийг үзүүлэлт тус бүрээр нь үнэлж жагсаахад ЖДҮ эрхлэгчид ядуурал, ажилгүйдэл, улс төрийн байдал, хээл хахууль, валютын ханш болон инфляци бусад үзүүлэлттэй харьцуулахад хамгийн хүндрэлтэй байна гэж үзжээ /Зураг 3.2/. Үүний дараагаар зээлийн хүү, гэмт хэрэг, гадаад өр, эдийн засгийн өсөлт болон зээлийн шимтгэл хураамж зэрэг үзүүлэлтүүд хүндрэлтэй гэсэн үр дүн гарлаа.

Харин мэдээлэл холбооны хөгжил болон цахилгаан түгээлтийг судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчид хамгийн сайн гэж дүгнэжээ. Түүнчлэн зах зээлийн өрсөлдөөн, технологийн дэвшил, тээвэрлэлт, усан хангамж, зам зэрэг нь бусад хүчин зүйлстэй харьцуулахад харьцангуй боломжийн гэж үзсэн байна.

Зураг 3.1: ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Зураг 3.2: ЖДҮ эрхлэгчдийн бизнесийн орчин /үзүүлэлтээр/

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

<sup>4</sup> 33 хүчин зүйлсийн хувьд маш муу, муу, боломжийн, сайн, маш сайн гэсэн чанарын хариулыг тоон утга руу /-2 оос +2/ индексжүүлэн тооцлоо.

### 3.2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨ

#### Нэгдсэн дүн

ЖДҮ-ийн бизнес эрхлэхэд макро эдийн засгийн орчны зүгээс бэрхшээл болж буй хүчин зүйлсийг маш муу /-2/-оос маш сайн /+2/ гэсэн чанарын асуултаар асууж, нэгдсэн үнэлгээг тоон утга руу шилжүүлэн тооцлоо.

Макро эдийн засгийн орчны хүчин зүйлсийг эдийн засгийн өсөлт, инфляци, валютын ханш, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад өр гэсэн таван үзүүлэлтээр тооцож бүлгийн индексийг гаргав. Түүвэр судалгааны үр дүнгээр макро эдийн засгийн орчны бүлгийн индекс (-0.71) буюу муу гэж дүгнэсэн байна /Зураг 3.3/.

Энэ удаагийн санал асуулгын дүнгээс харахад ЖДҮ эрхлэгчдэд макро эдийн засгийн орчны зүгээс валютын ханш, инфляци хамгийн их хүндрэл учруулдаг гэж судалгаанд оролцогчид хариулсан байна. ЖДҮ эрхлэхэд гадаад өр макро эдийн засгийн зүгээс инфляцийн дараа орох гол бэрхшээл гэж дүгнэсэн байна. Харин эдийн засгийн өсөлт болон гадаадын шууд хөрөнгө оруулалт бусад үзүүлэлттэй харьцуулахад бага зэрэг хүндрэл учруулж байна /Зураг 3.4/.


#### Аймаг, нийслэлээр

Макро эдийн засгийн орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Өмнөговь, Говь-Алтай аймгийн ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинд хамгийн муу үнэлгээг өгчээ. Хэнтий, Архангай аймгуудын ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад нийгмийн орчинг муу гэж үзжээ.

Харин Увс, Сэлэнгэ, Завхан болон Сүхбаатар аймгуудын ЖДҮ эрхлэгчид макро эдийн засгийн орчинг бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй бага хүндрэл учруулж байна гэж үзжээ.

Зураг 3.3: Макро эдийн засгийн нөлөө

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/




Зураг 3.4: Макро эдийн засгийн нөлөө /үзүүлэлтээр/

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Зураг 3.5: Макро эдийн засгийн нөлөө /аймгуудаар/

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

### 3.3 НИЙГЭМ, УЛС ТӨРИЙН БАЙДАЛ

Монгол улсын ДНБ-ий өсөлт 2016 онд 1.0%, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3,857<sup>5</sup> ам доллар байсан бөгөөд ажилгүйдлийн түвшин 9.1%-тай гарсан байна. Олон улсын “Transparency international” байгууллагын 2014 онд явуулсан судалгаагаар Монгол улсын авилгын индекс<sup>6</sup> 3.8 нэгж гарсан.

#### Нэгдсэн дүн

ЖДҮ-ийн бизнес эрхлэхэд нийгмийн орчны зүгээс саад болж буй хүчин зүйлсийг маш муу /-2/-оос маш сайн /+2/ гэсэн чанарын асуултаар асууж, нэгдсэн үнэлгээг тоон утга руу шилжүүлэн тооцлоо.

Нийгмийн орчны хүчин зүйлсийг ядуурал, ажилгүйдэл, хээл хахууль, гэмт хэрэг, улс төрийн байдал гэсэн таван үзүүлэлтээр тооцож бүлгийн индексийг гаргав. Түүвэр судалгааны үр дүнгээр нийгмийн орчны бүлгийн индекс (-0.99) буюу муу гэж дүгнэгдсэн хэдий ч өмнөх судалгаануудын дүнтэй харьцуулахад бага зэрэг сайжирсан байна /Зураг 3.6/.

Энэ удаагийн санал асуулгын дүнгээс харахад ЖДҮ эрхлэгчдэд нийгмийн орчны зүгээс ядуурал, ажилгүйдэл хамгийн их хүндрэл учруулдаг гэж судалгаанд оролцогчид хариулсан байна. ЖДҮ эрхлэхэд ажилгүйдлийн түвшин нийгмийн зүгээс ядуурлын дараа орох гол бэрхшээл гэж дүгнэсэн байна. Ядуурал болон ажилгүйдлийн түвшин бизнес эрхлэхэд голлох бэрхшээл болж, хэрэглэгчийн худалдан авалт буурахад нөлөөлж байна. Хэрэглэгчийн худалдан авалт муу байгаа нь ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтад сөргөөр нөлөөлж орлогыг бууруулж байна /Зураг 3.7/.


#### Аймаг, нийслэлээр

Нийгмийн орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Хэнтий, Говь-Алтай аймгийн ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинд хамгийн муу үнэлгээг өгчээ. Баянхонгор, Хөвсгөл аймгуудын ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад нийгмийн орчинг муу гэж үзжээ.

Харин Увс, Завхан, Өвөрхангай болон Төв аймгуудын ЖДҮ эрхлэгчид нийгмийн орчинг бусад аймгуудтай харьцуулахад харьцангуй бага хүндрэл учруулж байна гэж үзжээ /Зураг 3.8/.


Зураг 3.6: Нийгмийн орчин

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/




Зураг 3.7: Нийгмийн орчин /үзүүлэлтээр/

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Зураг 3.8: Нийгмийн орчин /аймгуудаар/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

<sup>5</sup> Дэлхийн банкны атласын аргачлал

<sup>6</sup> Энэхүү индекс нь 0-10 хооронд тодорхойлогдох бөгөөд 0-өндөр авлигатай, 10-бараг авлигагүй.

### 3.4. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчны хүрээнд ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж буй тодорхой ажлууд хийгдэж байгаа ч үр дүн, хэрэгжилт нь хангалттай бус гэж санал асуулгад оролцогсад үзсэн байна.

#### Нэгдсэн дүн

Энэ удаагийн түүвэр судалгааны үр дүнгээр хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчны бүлгийн индекс (-0.56) буюу муу гэж дүгнэгдсэн нь өнгөрсөн жилийн үзүүлэлтээс 0.07 нэгжээр буурсан үзүүлэлт гарчээ /Зураг 3.9/.

Хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчныг дотор нь задлан авч үзвэл хуулийн хэрэгжилт сул, төрийн байгууллагын үйлчилгээ хүнд сурталтай, татварын тогтолцоо муу байгаа нь ЖДҮ эрхлэхэд ихээхэн хүндрэл учруулж байна гэж үзжээ /Зураг 3.10/.


Судалгаанд оролцсон ЖДҮ эрхлэгчид хуулийн хэрэгжилтэд хамгийн муу үнэлгээг өгчээ. Манай улсад “Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль”, “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”, “Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль” жижиг дунд үйлдвэрлэлтэй холбоотой болон холбогдох хууль, журмын хэрэгжилт сул, хуулиа дагаж мөрддөггүйтэй холбоотой байх талтай.

#### Аймаг, нийслэлээр

Хууль эрх зүй, төрийн зохицуулалтын орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Баянхонгор аймаг хамгийн муу үнэлгээтэй гарсан. Түүний дараагаар Говь-Алтай, Хөвсгөл, Сүхбаатар аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих эрх зүйн орчин муу бүрдсэн гэж үзжээ. Харин Дорноговь, Дундговь, Баян-Өлгий, Увс аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад хууль эрх зүйн тогтолцоо, төрийн үйлчилгээ нь боломжийн байгаа гэсэн үнэлгээг өгсөн байна /Зураг 3.11/.

Зураг 3.9: Хууль эрх зүйн орчин

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/




Зураг 3.10: Хууль эрх зүйн орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Зураг 3.11: Хууль эрх зүйн орчин, аймгуудаар

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

### 3.5. ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

#### Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр зах зээлийн орчны бүлгийн индекс (-0.27) буюу харьцангуй боломжийн гэж дүгнэсэн нь өмнөх судалгаануудын дүнгээс эрс буурчээ /Зураг 3.12/.

Энэ удаагийн судалгаагаар зах зээлийн орчныг илэрхийлэх хүчин зүйлсээс хэрэглэгчдийн худалдан авах чадвар (-0.63) хамгийн муу үнэлгээтэй гарлаа. ЖДҮ эрхлэгчид хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурч байгаа нь бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна гэжээ /Зураг 3.13/.

Түүнчлэн технологийн дэвшил, зах зээлийн өрсөлдөөн зэрэг нь боломжийн байна гэж үзсэн нь судалгааны үр дүнгээс харагдлаа.


#### Аймаг, нийслэлээр

Зах зээлийн орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд болон Баянхонгор аймагт зах зээлийн орчин хамгийн муу үнэлгээтэй гарлаа. Булган, Говьсүмбэр аймгийн санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид улсын дундажтай харьцуулахад бизнес эрхлэх зах зээлийн орчин муу бүрдсэн гэж үзжээ /Зураг 3.14/.

Харин Дорноговь, Увс болон Баян-Өлгий аймгийн бизнес эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад зах зээлийн орчин боломжийн байгаа гэсэн үнэлгээг өгчээ.

**Зураг 3.12: Зах зээлийн орчин**

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/




**Зураг 3.13: Зах зээлийн орчин, үзүүлэлтээр**

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



**Зураг 3.14: Зах зээлийн орчин, аймгуудаар**

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)



### 3.6. САНХҮҮЖИЛТИЙН ОРЧИН

#### Нэгдсэн дүн

ЖДҮ эрхлэгчдийн дунд явуулсан түүвэр судалгааны үр дүнгээр санхүүжилтийн орчны индекс -0.64 гарсан бөгөөд ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн орчин төдийлөн сайнгүй байна гэж үзжээ. Энэ удаагийн судалгаагаар санхүүжилтийн орчин төдийлөн сайнгүй байна гэсэн үр дүн гарсан /Зураг 3.15/.

Санхүүжилтийн орчны индексийг үзүүлэлтүүдээр нь авч үзвэл зээлийн хүү ЖДҮ эрхлэгчдэд их хүндрэл болж байна. Түүний дараагаар зээлийн шимтгэл хураамж, зээлийн барьцаа хөрөнгө, зээлийн хугацаа, зээлийн хэмжээ болон зээлийн батлан даалт орж байна /Зураг 3.16/.

Түүвэр судалгааны үр дүнгээр зээлийн хүүнд өгсөн үнэлгээ (-0.87) өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг муудсан үзүүлэлттэй байгаа бөгөөд бизнес эрхлэхэд зээлийн хүү багагүй хүндрэл учруулж байна.

#### Аймаг, нийслэлээр

Санхүүжилтийн орчны индексийг аймаг, нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Дундговь аймгуудаас санал асуулгад хамрагдсан ЖДҮ эрхлэгчид санхүүжилтийн орчинд хамгийн муу үнэлгээ өгчээ.

Харин Архангай, Дорноговь, Увс зэрэг аймгууд санхүүжилтийн орчинг харьцангуй боломжийн гэж дүгнэсэн байна /Зураг 3.17/.

**Зураг 3.15: Санхүүжилтийн орчин**

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/




**Зураг 3.16: Санхүүжилтийн орчин, үзүүлэлтээр**

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



**Зураг 3.17: Санхүүжилтийн орчин, аймгуудаар**

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

### 3.7. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Дэд бүтцийн хөгжил нь аливаа улсын бизнес эрхлэхэд нөлөөлөх суурь хүчин зүйлсийн нэг юм. Тиймээс дэлхийн өрсөлдөх чадварын судалгаанд дэд бүтцийн хөгжлийг улс орнуудын өрсөлдөх чадвар, бизнес эрхлэхэд учирч буй саад бэрхшээлийг тодорхойлох 12 хүчин зүйлсийн нэгээр авч үздэг.

Энэ түүвэр судалгаагаар ЖДҮ-ийн хөгжилд дэд бүтцийн байдал хэрхэн нөлөөлж байгааг зам, дулаан шугам сүлжээ, тээвэрлэлт, усан хангамж, цахилгаан түгээлт болон мэдээлэл холбоо зэрэг хүчин зүйлсээр тодорхойлон авч үзлээ.

#### Нэгдсэн дүн

Түүвэр судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг бусад орчны бүлгийн индексүүдтэй харьцуулахад хамгийн бага хүндрэлтэй (0.01) буюу ерөнхийдөө боломжийн гэсэн үнэлгээг өглөө. Мөн өмнөх онтой харьцуулахад дэд бүтцийн байдал сайжирсан үнэлгээтэй гарсан байна.

Дэд бүтцийн орчны бүлгийн индексийг тодорхойлогч үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл дулааны шугам сүлжээ болон замын байдал бусад үзүүлэлттэй харьцуулахад бага зэрэг муу гэж дүгнэгдлээ. Харин цахилгаан түгээлт болон мэдээлэл холбооны салбарыг боломжийн сайн гэж дүгнэсэн байна /Зураг 3.19/.


#### Аймаг, нийслэлээр

Дэд бүтцийн орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Баянхонгор, Хэнтий, Дархан-Уул зэрэг аймгуудын ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдал хамгийн хүндрэлтэй гэж үзэж байна.

Харин Дундговь, Дорноговь, Архангай зэрэг аймгуудын ЖДҮ эрхлэгчид дэд бүтцийн байдлыг боломжийн гэж үзжээ.

Зураг 3.18: Дэд бүтцийн орчин

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/




Зураг 3.19: Дэд бүтцийн орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Зураг 3.20: Дэд бүтцийн орчин, аймгуудаар

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

# БҮЛЭГ 4




## ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ


Жилийн борлуулалтын орлого



Зардлын байдал



Дотоод орчин, үзүүлэлтээр



## ЖДҮ-ИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 4.1. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ

ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулахад дотоод орчны хувьд нөлөөлөх хүчин зүйлсийг ажиллах хүчний нийлүүлэлт, ажилчдын ур чадвар, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, барилга байгууламжийн хүрэлцээ, түүхийн эдийн олдоц, тоног төхөөрөмжийн чанар болон өрсөлдөх чадвар зэрэг үзүүлэлтүүдээр төлөөлүүлэн авч судаллаа.

Судалгааны үр дүнгээр ЖДҮ эрхлэгчид дотоод үйл ажиллагааны нөхцөлийг бага зэрэг хүндрэлтэй (-0.14) гэсэн үнэлгээг өглөө. ЖДҮ эрхлэгчдэд дотоод хүчин зүйлсээс бараа, бүтээгдэхүүний борлуулалт, ажиллах хүчний нийлүүлэлт илүү хүндрэл учруулдаг гэж үзэж байна. Үүний дараа шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, барилга байгууламжийн хүрэлцээ, ажиллах хүчний ур чадвар бага зэрэг хүндрэл учруулж байна. Өрсөлдөх чадвар, түүхий эдийн олдоц, тоног төхөөрөмжийн чанарыг сайнаар нөлөөлдөг гэсэн үнэлгээг өгсөн байна /Зураг 4.1/.

Дотоод орчны бүлгийн индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Ховд, Баянхонгор, Хөвсгөл аймгуудын үнэлгээ бусад аймгуудтай харьцуулахад хамгийн муу байна. Харин Өмнөговь аймагт ЖДҮ эрхлэгчдийн хувьд дотоод үйл ажиллагааны нөхцөлд эерэг үнэлгээ өгсөн байна. Баян-Өлгий, Архангай аймаг болон Улаанбаатар хотод дотоод үйл ажиллагааны нөхцөлийг харьцангуй боломжийн гэж үзжээ /Зураг 4.2/.

Дотоод орчныг тодорхойлогч үзүүлэлтүүдээр авч үзвэл Өмнөговь, Булган аймгуудын бизнес эрхлэгчдэд ажиллах хүчний нийлүүлэлт бусад аймгуудтай харьцуулахад илүү хүндрэлтэй байгаа бол Улаанбаатар хот, Увс аймагт эерэг үнэлгээтэй байна. Ажиллах хүчний ур чадварын хувьд Өмнөговь, Баянхонгор аймгууд хүндрэл ихтэй гэсэн хариултыг өгсөн бол Улаанбаатар хотод сайн гэж үзжээ.

Ховд, Баянхонгор, Өмнөговь аймгуудад бизнес эрхлэгчид шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж бусад аймагтай харьцуулахад илүү хүндрэлтэй гэж үзэж байна. Харин Дорноговь, Архангай, Дорнод болон Дархан-Уул аймгуудын ЖДҮ эрхлэгчид боломжийн гэж хариулсан байна.

Барилга, байгууламжийн хүрэлцээ Өмнөговь, Ховд, Хөвсгөл аймгуудад ЖДҮ эрхлэгчдэд бага зэрэг хүндрэлтэй гэсэн бол Увс, Дорнод, Төв аймагт үйл ажиллагаа эрхлэгчид боломжийн гэж үнэлсэн байна.


Зураг 4.1: Дотоод орчин, үзүүлэлтээр

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Зураг 4.2: Дотоод орчин, аймгуудаар

/-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Түүхий эдийн олдоцыг Баянхонгор, Ховд, Өмнөговь, Хөвсгөл, Булган аймгуудад бизнес эрхлэгчид бага зэрэг хүндрэлтэй гэсэн хариултыг хамгийн их өгсөн бол бусад аймагт үйл ажиллагаа эрхлэгчид бараг хүндрэлгүй гэж дүгнэж байна.

Тоног төхөөрөмжийн чанар Булган, Ховд, Хөвсгөл, Баянхонгор, Говьсүмбэр, Завхан, Дархан аймгуудын ЖДҮ эрхлэгчдэд бага зэрэг хүндрэлтэй, бусад аймгуудын хувьд харьцангуй хүндрэлгүй гэж үзжээ.

Харин өрсөлдөх чадварын хувьд ихэнх аймгуудын бизнес эрхлэгчид хүндрэлгүй гэсэн хариултыг өгсөн байна /Хүснэгт 4.1/.

## 4.2. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 75% нь жилд 50 сая хүртэлх төгрөгийн борлуулалтын орлоготой байна. Үүнээс 10-49 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой ЖДҮ хамгийн их буюу 40%-ийг эзэлж байхад 1.1-9.9 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой ЖДҮ 29%, 1 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой ЖДҮ 6%-ийг тус тус эзэлж байна.

50-500 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгч нийт судалгаанд оролцогсдын 5%-ийг эзэлж байгаа бол 500 саяас 1.5 тэрбум төгрөгийн орлоготой нь 20%-ийг эзэлж байна.

Энэ удаагийн судалгаанд 10-49 сая болон 500 сая-1.5 тэрбум хүртэлх төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-үүд өмнөх судалгаануудаас өндөр байгаа бол 1 сая хүртэл, 1.1-9.9 сая, 50-499 сая төгрөгийн орлоготой ААН-үүдийн тоо бага байна. Эндээс харахад ААН-үүдийн борлуулалтын орлогын түвшин өсч байгаа нь харагдаж байна. Мөн 50-499 сая төгрөгийн орлоготой ЖДҮ өнгөрсөн жилээс 13%-аар буурсан бол 500 сая-1.5 тэрбум төгрөгийн орлоготой ЖДҮ өнгөрсөн жилээс 16%-аар өссөн сонирхолтой үр дүн харагдаж байна /Зураг 4.3/.


### Хүснэгт 4.1: Дотоод орчин, үзүүлэлтээр

Я-2=маш муу, -1=муу, 0=боломжийн, 1=сайн, 2=маш сайн/

	Ажиллах хүчний нийлүүлэлт	Ажиллах хүчний үр чадвар	Түүхий эдийн олоц	Тоног төхөөрөмжийн чанар	Өрсөлдөх чадвар	Шилэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх	Барилга, байгууламжийн хүрэлцээ	Бараа, бүтээгдэхүүний борлуулалт
Улсын дүн	-0,14	-0,04	0,16	0,15	0,21	-0,06	-0,11	-0,26
Архангай	-0,14	0,06	0,40	0,40	0,23	0,03	-0,20	-0,17
Баян-Өлгий	-0,14	0,03	0,22	0,40	0,25	0,11	0,03	0,08
Баянхонгор	-0,48	-0,55	-0,34	-0,16	-0,44	-0,56	-0,29	-0,78
Булган	-0,72	-0,34	-0,22	0,04	0,00	-0,21	-0,21	-0,28
Говь-Алтай	-0,40	-0,48	0,28	0,04	0,24	-0,12	-0,20	-0,68
Говьсүмбэр	-0,35	-0,12	-0,11	-0,06	0,29	0,24	-0,29	-0,11
Дархан	-0,27	-0,27	-0,05	-0,02	0,02	-0,08	-0,15	-0,17
Дорноговь	0,00	-0,12	0,00	0,02	0,05	-0,02	-0,12	-0,10
Дорнод	-0,36	-0,32	0,10	0,23	0,28	0,02	0,17	-0,16
Дундговь	-0,47	-0,43	0,27	0,13	0,00	-0,13	-0,19	-0,39
Завхан	-0,54	-0,52	-0,11	-0,04	0,04	-0,17	-0,26	-0,32
Орхон	-0,45	-0,28	0,07	0,02	-0,21	-0,17	-0,25	-0,38
Өвөрхангай	-0,45	-0,32	-0,09	0,05	0,07	-0,05	-0,19	-0,16
Өмнөговь	-0,67	-0,67	-0,33	0,00	0,50	-0,50	-0,50	0,00
Сүхбаатар	-0,50	-0,50	-0,08	0,04	-0,08	-0,25	-0,21	-0,25
Сэлэнгэ	-0,39	-0,15	-0,04	0,00	0,18	-0,11	-0,11	-0,11
Төв	-0,32	-0,02	0,04	0,20	0,27	0,19	0,09	-0,10
Увс	0,00	0,29	0,00	0,00	-0,14	-0,40	0,67	0,40
Улаанбаатар	0,03	0,12	0,29	0,23	0,34	0,00	-0,06	-0,25
Ховд	-0,40	-0,43	-0,43	-0,38	-0,37	-0,52	-0,47	-0,58
Хөвсгөл	-0,56	-0,48	-0,27	-0,18	-0,25	-0,47	-0,37	-0,62
Хэнтий	-0,40	-0,49	-0,09	0,00	-0,09	-0,24	-0,24	0,00

### Зураг 4.3: Жилийн борлуулалтын орлого

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

### Борлуулалтын орлогын өсөлт

Барилга, газар тариалан, мал аж ахуй болон бусад үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд борлуулалтын орлого өссөн үзүүлэлт дунджаар 26,9% байна. Харин үйлчилгээ болон худалдаа эрхлэгчдийн 15%-ийнх нь борлуулалтын орлого өсчээ. Барилга, газар тариалан болон бусад үйл ажиллагаа эрхлэгчидтэй харьцуулахад 12 нэгжээр бага байна /Зураг 4.4/.

### Борлуулалтын орлогын өөрчлөлт

Судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 18% буюу 340 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтын орлого сүүлийн нэг жил өссөн бол 34% нь буюу 651 ЖДҮ-ийн борлуулалтын орлого буурсан. Харин дийлэнх хэсэг буюу 48%-д /918 ЖДҮ-ийг/ борлуулалтын орлогод өөрчлөлт гараагүй байна.


Нийт борлуулалтын орлого өссөн ЖДҮ эрхлэгчид дунджаар 18.7%-ийн өсөлттэй байсан байна. Харин борлуулалтын орлого буурсан ЖДҮ эрхлэгчид дунджаар 26.2%-ийн бууралттай байжээ. Судалгаанаас харахад ЖДҮ-үүдийн өнгөрсөн нэг жилийн борлуулалт дунджаар 5.6%-иар буурсан байна /Зураг 4.5/.

### Ашиг

Нийт судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн 40% нь сүүлийн нэг жилд ашигтай ажилласан байхад 16% нь алдагдалтай ажилласан байна. Түүнчлэн 40% нь ашиг, алдагдалгүй хэвийн ажилласан байна /Зураг 4.6/.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн борлуулалтын орлогыг аймгуудаар ангилан харвал Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар зэрэг аймгуудад болон Улаанбаатар хотод 50 хүртэлх сая төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-үүд хамгийн их хувьтай буюу 77%-иас дээш байхад Дархан, Сэлэнгэ зэрэг аймгуудад хамгийн бага буюу 48%-иас доош байна. Харин эсрэгээрээ Дархан, Сэлэнгэ зэрэг аймгуудад 50-иас дээш сая төгрөгийн орлоготой ААН-үүд дийлэнх хувийг нь эзэлж байна. Хамгийн их буюу 500 саяас 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ААН-үүд Сэлэнгэ, Дархан-Уул зэрэг аймгуудад 10%-иас дээш байна. /Зураг 4.7/

Зураг 4.4: Борлуулалтын орлогын өсөлт



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 4.5: Сүүлийн нэг жилийн борлуулалтын орлогын өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Зураг 4.6: Сүүлийн нэг жилд ашигтай ажилласан эсэх



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)



### 4.3. ЗАРДЛЫН БАЙДАЛ

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс тайлан, тэнцэл гаргадаг эсэх талаар асуухад судалгаанд оролцсон нийт ААН-үүдийн 63% нь тийм гэсэн хариултыг өгсөн байна. Энэхүү бүлэгт ЖДҮ эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагаагаа явуулахад гарах зардлын байдлыг тогтоож, ямар зардал ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл учруулж байгаа талаар авч үзэв.

Түүвэр судалгааны үр дүнгээр зардлын байдлын индекс (-0.98) буюу өмнө жилүүдэд хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг буурсан үзүүлэлттэй гарлаа. Энэ нь ЖДҮ эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаагаа явуулахад гарч буй зардлууд нь хүндрэлтэй хэвээр байгааг харуулж байна /Зураг 4.8/.

Зардлын бүлгийн индексийг үзүүлэлтүүдээр нь задлан авч үзвэл зээлийн хүүний зардал хамгийн их хүндрэлтэй байна. Түүний дараагаар төрийн үйлчилгээний шимтгэл хураамж, санхүүгийн байгууллагын шимтгэл хураамж, түүхий эд материалын зардал, түрээсийн зардал, цахилгааны зардал тоног төхөөрөмжийн зардал, дулааны зардал, ажиллах хүчний зардал, үйл ажиллагааны зардал, зам тээврийн зардал орж байна. Харин усны зардал болон харилцаа холбооны зардал нь бусад зардлуудаас харьцангуй бага хүндрэлтэй гэж хариуллаа /Зураг 4.9/.

Түүвэр судалгаанд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт зардлынхаа хамгийн өндөр буюу 46.8 орчим хувийг үйлдвэрлэлийн үндсэн зардал болох цалин, түүхий эдийн зардалд зарцуулдаг гэсэн үр дүн гарлаа.


Харин нийт зардлын 36.6 орчим хувийг үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал эзэлж байгаа бөгөөд үүнээс ажлын байрны түрээс, цахилгааны зардал хамгийн өндөр хувийг буюу 12.9%, 6.2%-ийг тус тус эзэлж байна.

Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын дараагаар үйл ажиллагааны (ҮА) үндсэн бус зардал буюу хүү, шимтгэлийн зардал ихээхэн хувийг эзэлж байна. Үүнд зээлийн хүүний зардал дунджаар 10.5%, шимтгэл, хураамжийн зардал дунджаар 6.1%-тай байна.

Нийт зардлын 9.8 орчим хувийг үйл ажиллагааны зардалдаа зарцуулдаг байна.


**Зураг 4.7: Жилийн борлуулалтын орлого, аймгуудаар**

(ЖДҮ-ийн хариулсан хувиар)




**Зураг 4.8: Зардлын байдал**

/-2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлгүй/



**Зураг 4.9: Зардлын байдал, үзүүлэлтээр**

/-2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлгүй/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)


ЖДҮ эрхлэгчдийн хувьд нийт орлогынхоо 82 орчим хувийг үйлдвэрлэлийн үндсэн зардал, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны үндсэн бус зардлуудад, харин 11.6 орчим хувийг татварын зардалд тус тус зарцуулдаг бол үлдсэн 6.4 орчим хувь нь хуримтлал буюу ашиг болдог байна.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад түүхий эд, ажлын байрны түрээс болон бусад зардал хамгийн их хэмжээгээр өссөн бол харилцаа холбоо болон цалингийн зардал их хэмжээгээр буурсан байна /Зураг 4.10/.

Зардлын байдлын индексийг аймаг болон нийслэл хотын хэмжээнд авч үзвэл Баянхонгор аймагт хамгийн их хүндрэлтэй гарсан байна. Түүний дараагаар Ховд, Дархан-уул, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын ЖДҮ эрхлэгчид бусад аймгуудтай харьцуулахад зардлын байдал их хүндрэлтэй байна гэж үзжээ.

Зардлын байдалд хамгийн тааруу үнэлгээ өгсөн Баянхонгор, Ховд, Дархан-Уул, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын хувьд зээлийн хүү болон шимтгэл, хураамж хамгийн хүндрэлтэй гэж хариулсан байна.

**Зураг 4.10: Зардлын хуваарилалт**



**Зураг 4.11: Зардлын байдал, аймгуудаар**

/-2= Их хүндрэлтэй, -1= Хүндрэлтэй, 0= Хүндрэлгүй/



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

## ДУГНЭЛТ

Бизнесийн идэвхи муудсанаар эргэлтийн хөрөнгөөр дутагдах, үйл ажиллагаагаа хэвээр үргэлжлүүлэх, цаашид үйлдвэрлэлээ өргөтгөхөд санхүүжилтийн бэрхшээл тулгарчээ. ЖДҮ эрхлэгчдэд Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас олгож буй хөнгөлөлттэй зээл төдийлөн хүртээмжтэй биш, олдоц бага бөгөөд арилжааны банкуудаас ихэвчлэн санхүүжилт авдаг байна. Голчлон, ЖДҮ эрхлэгчид 1-5 жилийн хугацаатай 10-50 сая төгрөгийн санхүүжилт авах сонирхолтой байдаг байна. Мөн ЖДҮ эрхлэгчдэд макро эдийн засгийн орчны зүгээс валютын ханш болон инфляци, нийгэм орчны зүгээс ядуурал болон ажилгүйдэл, хуулийн орчны зүгээс хуулийн сул хэрэгжилт болон төрийн байгууллагын үйлчилгээ хамгийн их хүндрэл учруулдаг байна.

Иймд УИХ, Засгийн газрын зүгээс татварын таатай орчин бүрдүүлэх, санхүүжилтийн хүртээмжийг өсгөх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, хуулийн орчинг сайжруулах болон авилгалыг бууруулах шаардлага тулгарч байна. Тухайлбал:

- Төр, хувийн хэвшлийн харилцааг хууль, журмын хүрээнд явуулж, хүнд суртлыг бууруулах, авилгыг арилгах;
- Төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах тэгш байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл олгох үйл явцыг нээлттэй ил тод болгох, ажлын байрыг ихээр бий болгох, эдийн засгийг салбаруудад төрөлжүүлэх;
- Шинээр бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагааны эхний үе шатанд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж үйл ажиллагаа нь тогтворжсон үед татвар ногдуулах;
- Дотоодод үйлдвэрлэх бүрэн боломжтой хэдий ч импортоор авч хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүнүүдийн хувьд татварын болон бусад зохицуулалт арга хэмжээг авч хэрэгжүүлэн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, дэмжих;
- Валютын ханшийн хэлбэлзлийг бууруулахад төрийн бодлого чиглэх шаардлагатай байна.

## ХАВСРАЛТ

### ОРОН НУТАГ, НИЙСЛЭЛ

#### Санхүүжилт авсан байдал

Түүвэр судалгааны үр дүнгээр Говьсүмбэр, Дундговь, Хөвсгөл, Дорноговь, Сэлэнгэ аймгуудад санхүүжилтэд хамрагдсан хувь (80%-иас дээш) бусад аймгуудаас харьцангуй өндөр байна. Харин Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ эрхлэгчдийн хувьд уг үзүүлэлт 43%-тай, Увс аймагт 37.5%-тай буюу хамгийн бага дүнтэй байна. Нийслэл хоттой ойролцоо буюу гадаад санхүүжилтэд харьцангуй бага хувьтай хамрагдсан аймгуудад Хэнтий, Баян-Өлгий, Архангай болон Өмнөговь зэрэг аймгууд багтаж байна /Хавсралт 1.1/.

#### Санхүүжилтийн эх сурвалж

Зураг 2.32-д хөдөө орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийн 86% нь банкнаас зээл авч санхүүждэг бол Улаанбаатар хотын ЖДҮ эрхлэгчдийн харьцангуй цөөн буюу 74% нь банкны зээлээр санхүүждэг байна. Харин Улаанбаатар хотын бизнес эрхлэгчдийн 13% нь ББСБ-аас санхүүжилтийн эх үүсвэрээ авсан байгаа нь орон нутагтай харьцуулахад 11 нэгж хувиар их үзүүлэлт юм.


Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ эрхлэгчдийн 9,6% нь хөнгөлөлттэй зээл авсан нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ЖДҮ эрхлэгчидтэй харьцуулахад 8 нэгж хувиар өндөр байна.

#### Санхүүжилтийн зарцуулалт

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ эрхлэгчдийн 71% нь санхүүжилтээ эргэлтийн хөрөнгөнд зарцуулсан нь орон нутгаас 13 нэгж хувиар өндөр үзүүлэлт юм.


Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчид харьцангуй эргэлтийн хөрөнгөнд санхүүжилтээ зарцуулдаг бол орон нутгийн ЖДҮ эрхлэгчид харьцангуй бизнесээ өргөжүүлэхэд санхүүжилтээ зарцуулдаг байна /Хавсралт 1.3/.

Хавсралт 1.1: Санхүүжилт авч байсан эзэх




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Хавсралт 1.2: Санхүүжилтийн Эх сурвалж



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Хавсралт 1.3: Санхүүжилтийн зарцуулалт



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)


### Санхүүжилт аваагүй шалтгаан

Түүвэр судалгаанд оролцсон нийт 1,909 ЖДҮ эрхлэгчдийн 846 буюу 44% нь өнгөрсөн хугацаанд ямар нэгэн гадаад санхүүжилтэд хамрагдаж байгаагүй /Зураг 2.8/. Говь-Алтай, Дорноговь, Өвөрхангай, Дорнод болон Улаанбаатар хотод өөрийн эх үүсвэрээр санхүүждэг учир санхүүжилт авах хэрэгцээ байгаагүй гэж хариулсан хувь (75%-иас дээш) бусад аймгуудтай харьцуулахад хамгийн өндөр байна. Харин Дундговь, Завхан, Хөвсгөл, Баян-Өлгий болон Сэлэнгэ аймгуудад зээл авах хэрэгцээ өнгөрсөн хугацаанд байсан хэдий ч зээлийн нөхцөл хүнд байгаагийн улмаас зээлд хамрагдаж чадаагүй гэж хариулсан ЖДҮ эрхлэгчдийн хувь (65%-иас дээш) бусад аймагтай харьцуулахад өндөр байна. Мөн Орхон, Ховд, Говьсүмбэр болон Хөвсгөл аймгуудад зээл авах нөхцөлийг хангаагүйн улмаас санхүүжилт аваагүй ЖДҮ эрхлэгчдийн хувь 13%-иас өндөр байна /Хавсралт 1.4/.

### Борлуулалтын орлогын өсөлт


Булган, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дархан болон Увс аймгуудад үйл ажиллагаа явуулдаг ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын орлого өссөн хувь (35%-иас дээш) бусад аймгуудтай харьцуулахад өндөр байна. Харин Өмнөговь, Улаанбаатар, Говь-Алтай, Баянхонгор, Төв болон Дорнод аймгуудад Борлуулалтын орлого өссөн бизнес эрхлэгчдийн хувь (15%-иас доош) бусад аймгуудтай харьцуулахад бага байна.

Хавсралт 1.4: Санхүүжилт аваагүй шалтгаан



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

Хавсралт 1.5: БО-ын өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Ашиг**

Архангай, Өмнөговь, Баян-Өлгий болон Өвөрхангай аймгуудад үйл ажиллагаагаа эрхэлдэг ЖДҮ-үүдийн ашигтай сүүлийн нэг жил ажилласан хувь (60%-иас илүү) хамгийн өндөр байна. Харин Увс, Говь-Алтай, Ховд, Орхон болон Өмнөговь аймгуудад сүүлийн жил алдагдалтай ажилласан ЖДҮ эрхлэгчдийн хувь хамгийн их буюу 25%-иас өндөр байна.

**Хавсралт 1.6: Ашигтай ажилласан эсэх**




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Цаашдын санхүүжилтийн хэрэгцээ**

Увс, Өмнөговь, Говьсүмбэр, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай болон Ховд аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ-ийн цаашид үйл ажиллагаа явуулахад санхүүжилт хэрэгцээтэй байгаа хувь (90%-иас дээш) хамгийн өндөр байна.

Харин Улаанбаатар, Төв, Дундговь, Дорнод болон Орхон аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ эрхлэгчдийн цаашид үйл ажиллагаа явуулахад санхүүжилт хэрэгцээгүй байгаа хувь (20%-иас дээш) өндөр байна.

**Хавсралт 1.7: Цаашид санхүүжилт шаардлагатай эсэх**



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)



### Ашиг алдагдал болон санхүүжилтийн хэрэгцээ

Өнгөрсөн 12 сарын хугацаанд ашигтай, алдагдалтай ажилласнаас үл хамааран ирээдүйд санхүүжилт авах сонирхолтой байгаа ЖДҮ эрхлэгчдийн хувь ойролцоогоор 65%-тай байна.

### Санхүүжилт авч байсан болон авах шаардлага

Өмнө нь санхүүжилт авч байсан ЖДҮ эрхлэгчдийн ирээдүйд санхүүжилт авах хувь өмнө нь санхүүжилт авч байгаагүй ЖДҮ эрхлэгчдээс дариу 22 нэгж хувиар илүү буюу 74,7%-тай байна.


### Ашигтай ажилласан эсэх

Барилга, газар тариалан, мал аж ахуй болон бусад үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд борлуулалтын орлого өссөн хэдий ч ашигтай ажиллаж чадаагүй байна. Харин үйлдвэрлэл эрхлэгчдийн тэн хагас нь 46% нь өнгөрсөн жил ашигтай ажилласан нь худалдаа, үйлчилгээний салбараас 8 нэгж хувиар, ХАА, барилгын салбараас даруй 30 нэгж хувиар илүү үзүүлэлт юм /Хавсралт 1.10/.

### Санхүүжилтийн шаардлага


Бүх салбарын ЖДҮ эрхлэгчдэд Санхүүжилтийн шаардлага тэн хагасаас нь илүүд хэрэгтэй байгаа хэдий ч санхүүжилт шаардлагатай худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн хувь үйлдвэрлэл болон бусад үйл ажиллагаа эрхлэгчидтэй харьцуулахад илүү бага байна /Хавсралт 1.11/.

**Хавсралт 1.8: Ашиг болон санхүүжилтийн хэрэгцээ**




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Хавсралт 1.9: Санхүүжилтийн туршлага болон шаардлага**




Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Хавсралт 1.10: Ашигтай ажилласан эсэх**



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)

**Хавсралт 1.11: Санхүүжилт шаардлагатай эсэх**



Эх сурвалж: Монголбанк, ЖДҮ эрхлэгчдийн түүвэр судалгаа (2017)